

Тус байгууллага нь анх 1971 онд Сайд нарын зовлолийн тогтоолоор Баян-Олгий аймгийн Нийгмийг аюулаас хамгаалах хэлтсийн дэргэд “Гал команд” нэртэйгээр байгуулагдаж, анхны даргаар Ц.Банди томилогдон, 25 хвнтэй, гал унтраах 2 автомашинтай үүрэг гүйцэтгэж эхэлсэн байна.

Монгол Улсын Засгийн газрын 1991 оны 3 дугаар сарын 15-ны одрийн 90 дүгээр тогтоолоор Цагдаагийн еронхий газрын Гал твймэртэй тэмцэх газар болсноор Гал команд нь бие даасан гал твймэртэй тэмцэх алба болж, улмаар аймгийн Засаг даргын 2000 оны 1 дүгээр сарын 27-ны одрийн 12 тоот захирамжаар Гал твймэртэй тэмцэх хэлтэс болон оргожсон байна.

Монгол улсын Засгийн газрын 2004 оны 51 дүгээр тогтоолоор Улсын иргэний хамгаалалтын газар, Гал твймэртэй тэмцэх газар, Улсын нооцийн газар зэрэг 3 байгууллагыг нэгтгэж, Онцгой байдлын алба болгосноор Баян-Олгий аймгийн Онцгой байдлын хэлтэс нь 3 дугаар зэрэглэлийн Гал унтраах 31 дүгээр анги, Эрэн хайх – аврах бүлэг, Нооцийн салбартайгаар аймгийн Засаг даргын дэргэдэх агентлагаар зохион байгуулагдсан.

2013 оны 6 дугаар сард батлагдсан шинэ бүтэц орон тоо, зохион байгуулалтаар ажиллаж, аймаг, орон нутгийн хэмжээнд гамшгаас хамгаалах арга хэмжээг толовлох, зохион байгуулах, хэрэгжүүлэхэд аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, иргэдийн вйл ажиллагааг уялдуулан зохицуулах, гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн голомтод аврах вйл ажиллагааг явуулж байна.

Баян-Олгий аймгийн Онцгой байдлын хэлтэс нь бүтцийн хувьд Урьдчилан сэргийлэх хяналтын тасаг, Гал унтраах 31 дүгээр анги, Эрэн хайх, аврах бүлэг, Улсын нооцийн салбар зэрэг нэгжтэй бөгөөд нийт 74 албан хаагчтай, гал унтраах үндсэн автомашин 2, усны цистерн 2, фургон 2, суудлын автомашин 1, ачааны ГАЗ- 66 автомашин 1, эмнэлгийн түргэн тусламжийн автомашин 1, 2 моторт завь болон бусад аврах багаж хэрэгсэлтэй үүрэг гүйцэтгэж байна.